



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/709

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2016 оны 234 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаан загалмайн хорооны нөөц сан бүрдүүлэх, Улаанбаатар хот болон бүсийн төвөөс тусламжийн бараа татах, сумдад сургалт сурталчилгаа явуулах арга хэмжээний зардалд зориулж 18000000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 18000000 төгрөг /Арван найман сая/-ийг Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 2.8 дахь “Ховд аймаг дахь гамшгийн сан бүрдүүлэх, сургалт сурталчилгаа, замын зардал” хөрөнгө оруулалтын зардлаас тооцож гаргахыг Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/709 Ch
02 3186

Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр
сарын 17-ны өдрийн А/709 дүгээр
захирамжийн хавсралт



УЛААН ЗАГАЛМАЙ ХОРООНЫ НӨӨЦИЙН САН БҮРДҮҮЛЭХ
ТӨСВИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Мянган төгрөг

№	Үйл ажиллагаа	Зардлын төсөв	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор аймгийн Улаан загалмайн хороонд гамшгийн нөөц бүрдүүлэх	Хүнсний багц /гурил, будаа, сахар, тос/	Багц	100	63,0	6300,0
		Ариун цэврийн багц	Багц	100	30,0	3000,0
		Малчдын тусламж /хужир, тэжээл, загасны тос	Багц	100	60,0	6000,0
2	Бүсийн төв Баян Өлгий аймаг болон МУЗН-ээс гамшгийн бараа татан авах	Тээврийн зардал	Тн/км	7000	0,3	2100,0
3	Сумдад тусламжийн бараа материалыг хүргүүлэх болон нийгмийн халдварт өвчин ковид-19 эсрэг сургалт, сурталчилгаа хийх, анхан шатны хороог бэхжүүлэх	Тусламжийн бараа түгээх зардал	Тн/км	2000	0,3	600,0
	Зардлын дүн					18000,0

-oOo-